



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 165

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 3 /гурав/ хуулийн этгээдийн “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг тус тус 5 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн
165 тоот тогтоолын
хавсралт



Тусгай зөвшөөрөл сунгасан хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж
1	Силвер стэндс ХХК	12100650	2025.08.31 2030.08.31	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
2	Бест оптек сервис ХХК	12100450	2025.08.19 2030.08.19	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх
3	Юнителком ХХК	12100011	2025.10.04 2030.10.04	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх